


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖК**

Дэлж оны 01 сарын 18 өдөр

Дугаар 108

Бөхт

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх “Соёлын төвд шинээр тоног төхөөрөмж нийлүүлэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга М.Цэвэгдорж (Багийн Засаг дарга)

Гишүүд Б.Амгаланжаргал (Засаг даргын Тамгын газрын
дарга)

Д.Номин-Эрдэнэ (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

Б.Нарандэлгэр (Газрын даамал)

Нарийн бичгийн дарга О.Амгалантөр (Нийгмийн бодлого
хариуцсан мэргэжилтэн)

2. Хууль тогтоомжид заасны дагуу баримт бичгийг бүрдүүлэн, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (М.Цэвэгдорж)-д, архивын нэгж үүсгэн баримтжуулж ажиллахыг нарийн бичгийн дарга (О.Амгалантөр)-д даалгасугай.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг үнэлгээний хороонд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

У.АЛТАНХҮҮ

